

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
1.1	Эцэг/эхийн нэр: Ланган Нэр: Отгонтуяа
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал УИХ-ын Төсвийн байнгын хорооны дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/: Тийм Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/: Үгүй
1.4	Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх: -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх; - Эдийн засагч мэргэжлээр бакалавр (1992 он), бизнесийн удирдлагын магистр (1998 он), удирдахуйн ухааны доктор (2007 он)-ын зэрэгтэй, дэд профессор (2008 он), профессор (2019 он) цолтой. -сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх; - Улс төрийн аль нэгэн намын гишүүн биш, улс төрийн үйл ажиллагаа явуулж байгаагүй. -зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх; - Ямар нэгэн зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй. -хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх; - Хувь хүний ёс зүй, нэр хүндийн хувьд ТТБЗ-ийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх зүйл байхгүй гэж үзэж байна. -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ. <ul style="list-style-type: none">• албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно);• удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;• хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.• эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар.

	<p>Ажилласан туршлага</p> <p>Нэг. 2020-2023 он (3 жил): УИХ-ын Төсвийн байнгын хорооны дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын газрын хаяг: Төрийн ордон, ТТБЗ-ийн ажлын алба-458, Улаанбаатар, 14201 <p>Хоёр. 1998-2023 он (25 жил): Удирдлагын академид 1998-2007 онд Төрийн удирдлагын тэнхимийн багш, ахлах багш, 2007-2009 онд Нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, 2009-2012 онд УА-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, 2010-2012 онд Удирдлага, бодлого, судлалын хүрээлэнгийн захирал, 2013 оноос Эдийн засаг, санхүүгийн удирдлагын тэнхимд дэд профессор, профессороор ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын газрын хаяг: Удирдлагын академийн гудамж-100, ХУД, УБ хот, 17012 <p>Гурав. 1994-1997 он (3 жил): Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн хэлтэст Төсвийн мэргэжилтэн</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын газрын хаяг: Дундговь аймгийн Нутгийн удирдлагын ордон, Мандалговь хот <p>Дөрөв. 1992-1994 он (2 жил): Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын орлогч</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын газрын хаяг: Дундговь аймгийн Сайнцагаан сумын ЗДТГ, Мандалговь хот <p>Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар.</p> <ul style="list-style-type: none"> - Судалгааны болон зөвлөх үйлчилгээний тайлан 32, эрдэм шинжилгээний илтгэл 21, эрдэм шинжилгээний өгүүлэл 25, нэг сэдэвт бүтээл нэгийг бичиж нийтлүүлсэн. Тайланд улсад зохион байгуулсан Олон улсын захиргааны сургуулиудын холбооны хуралд нэг удаа болон АНУ-ын Индианагийн Их Сургууль дээр болсон олон улсын хуралд хоёр удаа илтгэл тавьж, нийтийн хүртээл болгосон, “Татвар ба бизнес” сэтгүүлд эрдэм шинжилгээний 2 өгүүлэл монгол, англи хэлээр хэвлүүлсэн (Бүтээлийн жагсаалтыг хавсаргав).
1.5	<p>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар</p> <p>Хүсэлт гарагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; <ul style="list-style-type: none"> • Төсвийн байнгын хорооноос 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлэг болон УИХ-аас Хөгжлийн банкны асуудлаар 2022 онд хийсэн нийтийн сонсгол, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс 2022 онд зохион байгуулсан хуралд ТТБЗ-ийн даргын мэндчилгээ, саналыг оролцогчдод дамжуулан танилцуулснаас гадна эдгээр чиглэлээр ТТБЗ-ийн гишүүний хувьд өөрийн саналыг хэлж оролцсон. ТТХ, ТТБТХ-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар ТТБЗ-өөс оруулсан саналууд тусгагдан батлагдсан болно. • “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” үндэсний форумыг 2023.04.11-ны өдөр Сангийн яам, Жендэрийн үндэсний хороо, Удирдлагын Академи, Канад улсын гадаад хэргийн яамны санхүүжилттэйгээр хэрэгжсэн MERIT төсөл хамтран цахим, танхим хосолсон хэлбэрээр Монгол улсад анх удаа зохион байгуулсан. Үндэсний форумд УИХТГ, ЗГХЭГ, ТАЗ, бүх яамд, 21 аймаг, нийслэл хот, нийслэлийн 9 дүүргийн нутгийн удирдлагын төлөөлөл, мөн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын төлөөлөл, гадаадын зарим орны жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн мэргэжилтэн, зөвлөх, судлаачид буюу нийт 400 орчим (танхимд 170 хүн, цахимаар 200 гаруй хүн) хүн оролцсон (ЖМТ Үндэсний форумын хөтөлбөрийг хавсаргав). Миний бие тус форумын ерөнхий чиглүүлэгчээр болон зохион байгуулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан. Үндэсний форум нь

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, жендэрийн тэгш байдлыг хангах институцийн хэтийн төлвийн талаар нэгдмэл ойлголттой болох; жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг олон улсад хэрэгжүүлж буй туршлагаас суралцах; Монгол улсад жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр орон нутаг, салбар, үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжиж буй үйл ажиллагааг өргөжүүлэн эрчимжүүлэх; жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх төрийн өндөр түвшний оролцоог нэмэгдүүлэх; төрийн бодлого, салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах” зорилгын хүрээнд зохион байгуулагдсан юм. “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” үндэсний форумд оролцогчид хамтран зөвлөмж гаргасан.

- УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн ээлжит хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-ийн хараат бус гишүүнийг сонгох асуудлыг хэлэлцсэн бөгөөд ТТБЗ-ийн хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлж, нэр дэвшигчдээс нэг хүнийг Зөвлөлийн гишүүнээр томилох санал хураалтыг нууцаар, бичгээр явуулсан. Нэр дэвшигч миний бие хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь буюу хамгийн олон санал авсан тул Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус гишүүнээр томилох Төсвийн байнгын хороо (ТБХ)-ны тогтоолын төслийг баталсан (Энэ талаарх мэдээлэлтэй <http://parliament.mn/n/ixpy> холбоосоор нэвтэрч танилцах боломжтой). Мөн ТБХ-ны 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 04 тоот тогтоолыг хавсаргав.
- ТБХ, ТТБЗ-өөс 2020 оны 9 дүгээр сарын 29-нд Төрийн ордны Их эзэн Чингис хаан танхимд зохион байгуулсан “Монгол улсын Үндсэн хуульд төсвийн чиглэлээр оруулсан өөрчлөлт ба төсвийн төлөвлөлтийн цаашдын хандлага” сэдэвт хэлэлцүүлэгт “Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн өнөөгийн байдал, төсвийн төлөвлөлтийн цаашдын хандлага, Олон улсын туршлага” сэдвээр илтгэл тавьж оролцсон (Урилга, хөтөлбөр, илтгэлийг хавсаргав). Энэхүү хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга нар оролцсон бөгөөд УИХ-ын ТБХ-ны дарга Б.Жавхлан судлаачдын багаас төсвийн зарлагын удирдлагын чиглэлээр хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан төсвийн шинэчлэл, төсөвлөлтийн асуудлаар хамтарч ажиллах саналыг тавьсан.
- Төрийн удирдлагын докторын ажил хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр БСШУ-ны сайдын 2017 оны А/251 дугаар тушаалаар томилогдон 2017-2023 онд нийт 15 докторын судалгааны ажлыг хамгуулуулах зөвлөлийн гишүүнээр ажилласан. Үүнээс гадна Удирдлагын академийн Эрдмийн зөвлөлийн гишүүнээр 2009-2012, 2019-2023 онд, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн судалгааны зөвлөл болон “Татвар ба бизнес” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр 2021-2023 онд ажиллаж байна.
- ЗГХЭГ-ын захиалгаар 2019 онд “Монгол улсад хэрэгжиж буй төсвийн зарлагын удирдлагын шинэчлэл: Туршлага, сорилт” судалгааны ажлыг гүйцэтгэх багийн ахлагчаар ажиллаж, захиалагчид хүлээлгэж өгсөн. 2013-2014 онд УИХТГ, ТБХ-ны захиалгаар “Монгол Улсын нэгдсэн төсвийн өнөөгийн байдал, цаашдын хандлага” судалгааг Монголын төсвийн мэргэжилтнүүдийн холбооны судлаачдын багийг ахлан гүйцэтгэж, судалгааны тайланг УИХ-ын төсвийн байнгын хороонд хүлээлгэн өгч УИХТГ-ын хэвлэх үйлдвэрт 2014 онд хэвлүүлсэн.
- Удирдахуйн ухааны докторын зэргийг 2007 онд “Төсвийн зарлагын төлөвлөлтийг боловсронгуй болгох нь” сэдвээр Удирдлагын Академид хамгаалж, “Төсвийн зарлагын удирдлага, төлөвлөлт” нэг сэдэвт бүтээл хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон. Энэхүү бүтээлээс УА-ийн доктор Б.Баясгалан, МУИС-ийн доктор Д.Оюунцэцэг, Н.Бурмаа нар докторын судалгааны ажилдаа ишлэл авсан, судалгааны үр дүнд тулгуурлан Тайланд улсад нэг удаа болон АНУ-д болсон олон улсын хуралд хоёр удаа илтгэл тавьж, хэлэлцүүлсэн.
- Төсвийн зарлагын төлөвлөлтийн орчин үеийн хандлага болох “Оролцоот төсөвлөлт”, “ТХЗ-д суурилсан төсөвлөлт”, “Байгаль орчинд ээлтэй төсөвлөлт”, “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”, “Хүүхдэд ээлтэй төсөвлөлт”-ийн чиглэлээр НҮБХХ, НҮБХАС, НҮБХС, ШХА, ГОУХАН, Канадын MERIT төсөлтэй 2014-2023 онд хамтран ажиллаж богино хугацааны болон цахим (онлайн) сургалтын модуль, сургалтад ашиглах дижитал материал, гарын авлагуудыг бэлтгэн гаргаж, Удирдлагын Академид хүлээлгэн өгч тогтвортой байдлыг ханган ажиллаж байна.
- Удирдлагын Академид 1998 оноос эхлэн тасралтгүй 26 дахь хичээлийн жилдээ ажиллаж байна. Төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн

	<p>мэргэшүүлэх багц сургалт, төрийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагаар мэргэшсэн менежер, магистр бэлтгэх сургалтуудад “Төсвийн төлөвлөлт, удирдлага”, “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага”, “Төрийн санхүү, төсвийн удирдлага”, “Орон нутгийн эдийн засаг, санхүүгийн удирдлага”, “Худалдан авах ажиллагаа” зэрэг мэргэшүүлэх хичээлийг хариуцан танхим болон цахимаар заадаг. Түүнчлэн богино хугацааны модуль сургалтад төсөв, төрийн санхүү, төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, ИТХ-ын төсөв, санхүү, өмчлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр практикт суурилсан хичээлүүдийг зохион байгуулдаг. Заах хичээлийнхээ хөтөлбөр, агуулга, төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, лекц, үзүүлэн таниулах материал, семинарын хичээлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн бэлтгэж, хичээлүүдийн модуль, багцыг Удирдлагын Академийн стандартын дагуу бэлтгэн сургалтыг оролцооны аргад тулгуурлан явуулдаг. Багшлах хугацаандаа өөрийн заадаг хичээлүүдээр 25,000 гаруй цагийн сургалт, эрдэм шинжилгээ, зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэсэн бөгөөд төсөв, төсвийн төлөвлөлт, улсын болон орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, татвар, төсвийн зарлагын удирдлага, төлөвлөлт, шинжилгээ, төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, төсвийн алдагдал, өрийн удирдлага, зарлагын үр ашиг, үр дүнг судлах чиглэлээр 170 орчим сонсогчийн дипломын ажил, 221 магистрын ажил, 1 докторын судалгааны ажлыг удирдаж, 2 докторын зөвлөх комиссын гишүүнээр ажиллаж амжилттай хамгаалуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу 1992-1994 онд нутгийн захиргааны байгууллагад төсөв, санхүүгийн асуудлыг хариуцан сумын Засаг даргын орлогч бөгөөд Санхүү тасгийн дарга, аймгийн төсвийн мэргэжилтнээр ажиллах хугацаандаа тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, статистикийн мэдээ, тайлан гаргах, өмч хөрөнгийн ашиглалт, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, шинжилгээ хийх ажлыг гардан гүйцэтгэж байсан.
1.6	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар:</p> <p>Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. - Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноог бичнэ. • “Монголын төсвийн мэргэжилтнүүдийн холбоо” ТББ-ыг үүсгэн байгуулж, удирдах зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1 тоот шийдвэрээр захирлаар томилогдсон. Тус холбоо 2013-2014 онд ажилласан боловч 2015-2023 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байгаа болно. • “Төсвийн удирдлагын хүрээлэн” НҮТББ-ыг 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд өнөөг хүртэл удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.
1.7	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> - Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. • Нэг сэдэвт бүтээл, гарын авлага 21-ийг бичиж, нийтлүүлсэн. Тухайлбал, “Төсвийн зарлагын удирдлага, төлөвлөлт” (2007) нэг сэдэвт бүтээл, “Төрийн санхүүгийн удирдлага” (2002, 2009) гарын авлага, “Менежментийн шинэ парадигма” (2007, 2014) гарын авлага, “ИТХ-ын Төлөөлөгчдийн сургалт”-ын гарын авлага (2013, 2016, 2020), “Хүүхдэд ээлтэй орон нутгийн засаглал” (2015) зэрэг гарын авлага хэвлүүлж нийтийн хүртээл болгож, ТАХ-дын сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болгон ажиллаж байна (Бүтээлийн жагсаалтыг хавсаргав). • Засгийн газар, олон улсын болон төрийн, төрийн бус байгууллагын захиалгаар нийт 32 судалгаа, зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэсний 8 судалгааны ажлын багийн ахлагчаар, 24 ажлын үндсэн судлаач, бие даасан зөвлөхөөр ажиллаж захиалагчид хүлээлгэн өгсөн (Бүтээлийн жагсаалтад тодорхой тусгасан). • Эрдэм шинжилгээний илтгэл 21, эрдэм шинжилгээний өгүүлэл 25, орчуулга 1, номд бичсэн бүлэг, зүйл 6, хянан тохиолдуулсан, редакторласан бүтээл 6 байгаа (эдгээр бүтээлийн сэдэв, нэр, хэвлэгдсэн эх сурвалжийг бүтээлийн жагсаалтаас үзнэ үү).

1999-2023 онд нийт 112 бүтээл бичиж, нийтлүүлсний 53 нь сүүлийн 10 жилийн хугацаанд хэвлэгдсэн, мөн 9 нь англи хэлээр гарсан байна.

- Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.
 - ТТБЗ-өөс 2020-2024 онд Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжид өөрийн саналыг тусгахын зэрэгцээ ТТБЗ-ийн санал, дүгнэлт, зөвлөмжийг эцэслэн боловсруулах ажлыг гүйцэтгэж ирсэн (Энэ талаарх мэдээллийг ТТБЗ-ийн дарга, ажлын албанаас тодруулах боломжтой).
 - ТТБЗ-ийн 2020, 2021, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, 2018-2022 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, ТТБЗ-өөс холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах “Ойлголцлын санамж бичиг”-ийн төсөл, ТТБЗ-ийн 2021, 2022 оны гадаад сургалтын төлөвлөгөө боловсруулах зэрэг ажлыг Зөвлөлийн даргын өгсөн үүргийн дагуу хариуцан гүйцэтгэж байсан.
 - Сангийн яам, Жендэрийн үндэсний хороо, Удирдлагын Академи, Канад улсын гадаад хэргийн яамны санхүүжилттэйгээр хэрэгжсэн MERIT төсөл хамтран Монгол улсад анх удаа 2023.04.11-ны өдөр зохион байгуулсан “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” үндэсний форумд оролцогчдод Монгол Улсын Ерөнхий сайдын ирүүлсэн мэндчилгээний төслийг боловсруулж, Ерөнхий сайдын зөвлөхүүдэд илгээсэн (Ерөнхий сайдын мэндчилгээг хавсаргав).
- Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.
 - 1) 2019-2023 онд Удирдлагын академид төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт, төрийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагаар мэргэшсэн менежер, магистр бэлтгэх сургалтад хамрагдсан 3000 орчим Төрийн албан хаагчдад “Төсвийн төлөвлөлт, удирдлага”, “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага”, “Төрийн санхүү, төсвийн удирдлага”, “Орон нутгийн эдийн засаг, санхүүгийн удирдлага”, “Худалдан авах ажиллагаа” зэрэг мэргэшүүлэх хичээлийг нийт 3300 сургалтын цагт багтаан цахим, танхимын хэлбэрээр явуулж, лекц уншиж, семинарын хичээлийг зохион байгуулсан.
 - 2) 2022 оны 9-10 дугаар сард БХЯ, УУХҮЯ, ГХЯ, НХХЯ, БШУЯ, СЯ болон эдгээр яамны харьяа агентлаг, байгууллагуудын удирдах ажилтнууд, түүнчлэн Хэнтий, Өмнөговь, Дундговь аймгийн болон сумдын, мөн Баянзүрх дүүргийн төрийн албан хаагчид, Эрдэнэс Монгол ХХК-ийн удирдах бүрэлдэхүүн тус бүр 100 хүн, нийт 1400 хүн хамрагдсан “Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого” сэдэвт цахим, танхим (1-2 өдрийн), цахим хосолсон сургалтыг зохион байгуулж, сургалтын багийг ахлан ажилласан. Энэ сургалтад “Алсын хараа 2050” - Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, “Эдийн засаг”, “Бүс, орон нутгийн хөгжил”, “Улаанбаатар ба дагуул хот” модуль, “Шинэ сэргэлтийн бодлого” сэдвийг хариуцан лекц уншиж, оролцооны аргад тулгуурлан интерактив байдлаар сургалтыг явуулж, ТАХ нар цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа төлөвлөхөд нь дэмжлэг үзүүлсэн болно.
 - 3) Сүүлийн 5 жилд дараах илтгэлүүдийг хэлэлцүүлсэн болно. Үүнд:
 - MERIT төсөл хэрэгжсэн Сүхбаатар, Дорнод, Төв, Дундговь аймгийн ЗДТГ болон ТАЗ, ЗГХЭГ, холбогдох яамд, агентлагууд, ЖҮХ, Удирдлагын академийн төлөөлөл болох 80 орчим хүн оролцсон “Хүний нөөц, жендэрийн мэргэжилтэн, манлайлагчдын нэгдсэн чуулга уулзалт” дээр “Жендэрийн тэгш байдлын чиглэлээр төрийн албан хаагчдыг чадавхжуулах нь (АТЖДШ+, ЖМТ)” илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн. Чуулга уулзалт 2023 оны 11 сарын 16-17-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод зохион байгуулагдсан (Хөтөлбөрийг хавсаргав). ЖМТ-ийн чиглэлээр хэрэгжсэн үйл ажиллагааны мэдээллийг MERIT төслийн Facebook хуудас болон MERIT мэдлэгийн портал <http://portal.merit.mn/>

	<p>аас үзэх боломжтой.</p> <ul style="list-style-type: none"> • Удирдлагын академи MERIT төсөлтэй хамтран орон нутагт хэрэгжүүлсэн “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” төслийн үр дүн, туршлага. Сангийн яам, ЖҮХ, Удирдлагын академи, MERIT төслөөс хамтран зохион байгуулсан “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” үндэсний форумын “Орон нутаг, байгууллага, нэгжийн түвшинд хэрэгжүүлсэн ЖМТ-ийн үр дүн” сэдэвт панел хэлэлцүүлэгт тавьсан илтгэл. 2023.04.11, Улаанбаатар (1.5 х.х.) • Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн өнөөгийн байдал, төсвийн төлөвлөлтийн цаашдын хандлага (Олон улсын туршлага). УИХТГ, ТБХ, ТТБЗ-өөс хамтран зохион байгуулсан хуралд тавьсан илтгэл. 2020.09.29, Улаанбаатар (1 х.х.) • Төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо. Иргэдийн оролцоо чуулганд тавьсан илтгэл. УА, КАС, ШХА. 2019.12.02, Улаанбаатар (2.5 х.х.) • Тэгш бус байдлыг бууруулах талаар судалгаа явуулах төлөвлөгөө байна уу? “Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах нь: Мэдлэгээс төрийн бодлогод” ЮНЕСКО-ийн нийгмийн өөрчлөлтийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан хурал, УИХТГ, ШУА, ЮНЕСКО-гийн МОСТ хөтөлбөр. Төрийн ордон, Нээлттэй сонсголын танхим, 2019.07.17-19, Улаанбаатар (1.1 х.х.) <p>- Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Сүүлийн 5 жилийн хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараах ярилцлагыг өгсөн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) 2023.10.19-нд Ийгл ТВ-ийн Тоон тоймд ТТБЗ-өөс 2024 оны төсвийн төсөлд төсвийн зарлагатай холбоотойгоор гаргасан дүгнэлт, зөвлөмжийн талаар ярилцлага өгсөн, https://fb.watch/nXbLwy7jsD/?mibextid=v7YzmG линкээр орж ярилцлагыг үзэх боломжтой. Нэвтрүүлгийн файлыг нь хуулбарлан ТТБЗ-ийн ажлын албанд хүргүүлсэн. 2) 2022.10.28-нд Үндэсний ТВ буюу MNB TV-ийн Өглөө хөтөлбөрийн “Тэгш боломж-Тэгш хариуцлага” булангийн 8 дахь дугаарт ЖҮХ-ны Нарийн бичгийн дарга Т.Энхбаяртай Монгол улсад Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үндэсний чадавхыг бүрдүүлж буй талаар ярилцсан. Ярилцлагыг https://www.youtube.com/watch?v=R54pCb-L0Mk линкээр орж үзэж болно. 3) 2022.10.27-нд Ийгл ТВ-ийн Тоон тойм нэвтрүүлэгт Төсвийн сахилга батыг хангах талаар УИХ, улс төрчид хэрхэн анхаарч ажиллах талаар товч ярилцлага өгсөн. Видео бичлэгээс өөрийн ярилцсан хэсгийг хэсэгчлэн авч хавсаргав. 4) 2022.10.26-нд Ийгл ТВ-ийн “Нэг сэдвээр” нэвтрүүлэгт Сангийн яам болон ТӨБЗГ-ын төлөөллийн хамт оролцож, ярилцлага өгсөн (Видео бичлэгийг хүргүүлэв). 5) 2021.11.01-нд Ийгл ТВ-ийн Зочны цаг нэвтрүүлэгт оролцож, ТТБЗ-өөс 2022 оны төсөвт өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар ярилцсан. 6) 2020 оны 11-р сард ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуугийн өгсөн үүргийн дагуу Ийгл ТВ-ийн “Тоон тойм” нэвтрүүлэгт ТТБЗ-ийн 2021 оны төсөвт өгсөн дүгнэлт, саналын талаар ярилцлага өгч олон нийтэд танилцуулсан. <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p>
1.8	<p>Эрүүгийн хариуцлага</p> <p>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ - Үгүй</p> <p>- И-Монголиа-гаас Цагдаагийн ерөнхий газрын тодорхойлолт авч хавсаргав.</p>
1.9	<p>Сахилгын шийтгэлийн талаар</p> <p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх – Үгүй</p> <ul style="list-style-type: none"> • Сахилгын шийтгэл хүлээж байгаагүй.

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p>
	<p>Хийх ажил:</p> <p>Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд томилогдвол миний бие дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1) Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан тусгай шаардлагыг хангаж ажиллахад голлон нөлөөлөх хүчин зүйл болох төсвийн зарлагын удирдлагыг сайжруулахад мэргэжил, арга зүйн үндэслэл бүхий судалгаанд тулгуурласан зөвлөмж, саналыг боловсруулж ажиллах2) Төсвийн тухай хуульд болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.4 дэх заалтад 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу ТТБЗ-өөс “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлыг таамаглах ...”-д хэрэглэх аргачлал, тооцооны үндэслэлийг гаргаж боловсруулах чиглэлээр Зөвлөлийн гишүүд, Ажлын албаны ажилтнуудтай нягт хамтран үр дүнтэй ажиллах3) Монгол улсад төсвийн болон татварын тогтолцооны шинэчлэлийг хийх үндэслэлийг тодорхойлох судалгааг хийж, шинэчлэлийн үндсэн чиглэлийг боловсруулахад оролцох4) Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Жайка байгууллагаас боловсруулж хэрэгжүүлж буй Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үндсэн найман үе шатыг Монгол улсад үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, түүний шалтгааныг тодорхойлох судалгааг хийж, шийдвэрлэх боломжит хувилбаруудыг боловсруулах5) Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцож, шинжлэх аргачлалыг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албаны болон УИХТГ-ын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ажилтнуудад сургалт явуулж, практикт хэрэглэхэд нь коучинг хийж, зөвлөн тусалж, чиглүүлэх6) Монгол улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын зорилтууд болон төсвийн уялдааг хангахад чиглүүлэн төсвийн зарлагын Чиг үүргийн ангилал (Classification of Functions of Government - COFOG)-ыг нэвтрүүлж, мөрдөх талаар Засгийн газар, Сангийн яаманд холбогдох зөвлөмжийг ТТБЗ-өөс 2024 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжид тусгасныг хэрэгжүүлэхийг шаардаж ажиллах7) Төсвийн зарлагын чиг үүргийн ангиллыг нэвтрүүлж, мөрддөг болсон тохиодолд зарлагыг түүнийг зарцуулснаар хүрэх үр дүнтэй нь холбож төлөвлөж, төсөвлөж, шийдвэр гаргаж, хэрэгжүүлж, тайлагнаж, хянан шинжилж, үнэлж, хянах нөхцөл бүрдэнэ. Ингэснээр төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хариуцах үр дүнгийн үзүүлэлт, дунд хугацааны төсвийн зарлага (ДХТЗ)-ын хүрээ, төсвийн хязгаар, төсвийн зарлагын хөтөлбөр, түүний шалгуур үзүүлэлтийг харилцан уялдаатайгаар тодорхойлж хэрэглэх шаардлагатай болно. Үүний тулд:<ul style="list-style-type: none">• ТЕЗ бүр төсвийн хязгаартаа буюу УИХ, ИТХ-аар батлагдсан төсвийн урсгал зардал, хөрөнгийн зардал болон гадаадын зээл, тусламжийн нийт дүндээ багтаан өөрийн хариуцах зарлагын хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон хүрэх үр дүнг хангаж, үүний төлөө хариуцлага хүлээн ажилладаг болохыг шаардах• Төсвийн зарлагын үр ашиг, үр дүнг сайжруулж, дунд хугацаанд хүрэх зорилго, зорилтоо хангахын тулд жил бүр төсвийн зарлагыг нэмэгдүүлэхээс илүүтэй салбар хооронд болон салбарын дотоодод зарлагыг дахин эрэмбэлж хуваарилах тогтолцоонд шилжихэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах• Австри улсын туршлагаас суралцсаны үндсэн дээр улс орны урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүнд тулгуурлан салбар тус бүрийн үүрэг хариуцлага, салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг чухалчлан ажиллахад шаардагдах аргачлалыг боловсруулах

	<ul style="list-style-type: none"> • Үр дүнд чиглэсэн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг олон улсын нийтлэг хандлагад нийцүүлэн Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт, Хүүхдэд ээлтэй төсөвлөлт, Байгаль орчинд ээлтэй төсөвлөлт, Тэргүүлэх чиглэлд тулгуурласан төсөвлөлт, Оролцоот төсөвлөлтийн аргуудыг нэвтрүүлж, бодитой хэрэгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах болно. <p>8) Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх, Төрийн бүтээмжийн сэргэлтийг хийхийн тулд төрийн зорилго, төсвийн гүйцэтгэлийг хэмжих цогц үзүүлэлтүүд болох төсвийн зарлагын үр өгөөж, хэмнэлт, үр ашиг, бүтээмж, үр дүн, тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэгийг бүх шатны төсвийн захирагч нар, ТАХ-дад нэгдмэл байдлаар эзэмшүүлж, салбар, орон нутаг, төсвийн байгууллага бүрийн стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагнал, хяналт шинжилгээ, үнэлгээ, хяналтад нэг мөр хэрэглэдэг болоход дэмжлэг үзүүлэх</p> <p>9) ТТБЗ-ийн зүгээс төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлыг таамаглах ажлыг гүйцэтгэхэд шаардагдах олон жилийн тоон мэдээллийн санг бүрдүүлж, ашигладаг болоход анхаарч ажиллана.</p> <p>Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшсэн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Макро эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр эдийн засагч мэргэжил эзэмшиж, орон нутгийн нэгжээс буюу сум, аймгийн төсөв, санхүүгийн байгууллагаас эхлэн эзэмшсэн мэргэжлээрээ тасралтгүй 30 гаруй жил ажиллаж, эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр онол, арга зүйн мэдлэг, ур чадвар, практик туршлага хуримтлуулсан. • Төрийн удирдлагаар мэргэшиж, бизнесийн удирдлагын магистр, удирдахуйн ухааны докторын зэрэг хамгаалж, төрийн санхүү, төсвийн удирдлага, улсын болон орон орон нутгийн төсвийн харилцаа, төсвийн төвлөрөл сааруулалт, орон нутгийн эдийн засаг, санхүүгийн удирдлага, өмчийн харилцаа, төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, төсвийн шинэчлэл, төсвийн зарлагын удирдлага, төлөвлөлтийн чиглэлээр төрийн албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтууд, бакалавр, магистр, докторын сургалт, богино хугацааны модуль сургалтыг практик хэрэгцээнд тулгуурлан насанд хүрэгчдэд 25 гаруй жил явуулж ирсэн. • Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого болон төсвийн уялдааг хангах чиглэлээр буюу “Үр дүнд чиглэсэн дунд хугацааны төсвийн зарлагын төлөвлөлт” -ийг Монгол улсад хэрэгжүүлэхэд чиглэсэн судалгааг хийж, төсөвлөлтийн шинэ хандлагуудын талаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд, ИТХ-ын Төлөөлөгчид, иргэд, ИНБ, ТББ-уудад сургалт явуулж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг сүүлийн 15 жил гүйцэтгэсэн. • Удирдлагын бүх түвшний төрийн албан хаагчидтай ажиллах, мэдлэг, ур чадвараа хуваалцах, албан баримт бичиг, төлөвлөгөө, тайлан боловсруулах, хянан нягтлах, нотолгоо баримтад тулгуурлан илтгэх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг хувь хүний ур чадварыг эзэмшсэн. • Төсвийн байнгын хорооны дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус гишүүнээр 2020 оны 10 дугаар сараас өнөөг хүртэл 3 жил гаруй ажиллаж байгаа.
--	---

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: **Ланган**

Өөрийн нэр: **Отгонтуяа**

Гарын үсэг:

Он, сар, өдөр: **2023 оны 12 дугаар сарын 5-ны өдөр**

--- oOo ---